



Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”¹-д эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онуудад эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 үр дүнг жагсаасны 5-д “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”²-д эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын дор эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлийг тодорхойлсонд “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ” гэж багтаасан.

Монгол Улсын Их Хурлын ээлжит 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр³-ийг Монгол Улсын Их Хурал 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт дэвшүүлсний “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээ засаглалын бодлогын хүрээнд мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилт тодорхойлсон.

¹ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020.05.13)
<https://www.legalinfo.mn/annex/details/11057?lawid=15406>

² Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)
<https://legalinfo.mn/annex/details/11213?lawid=15584>

³ Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020.08.28)
<https://legalinfo.mn/annex/details/11057?lawid=15406>

Дээр дурдсан төрийн бодлогын баримт бичгээс цаг хугацааны хувьд урд батлагдсан мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичгүүд байна /он цагийн дарааллаар жагсаав/. Тухайлбал,

Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги: Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”⁴–д мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хэрэглээг хөгжүүлэх зорилтын хүрээнд “Мэдээлэл, холбооны технологийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлэх, мэдээллийн технологийн хэрэглээг дэмжих зорилгоор мэдээллийн аюулгүй байдал болон мэдээллийн технологийн тухай хуулийн төсөл боловсруулах”; “мэдээллийн технологийн хөгжлийг дэмжих зорилгоор холбогдох хууль эрхийн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж тусгасан.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал: Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”⁵–д гадаад харилцааны бодлогын чиглэлүүд тодорхойлсонд мэдээллийн технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт, орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухаан-технологи, оюуны өмчийн салбарт хоёр талын болон олон талын үндсэн дээр хамтын ажиллагаа хөгжүүлэх гэж дурдагдсан.

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого: Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/”⁶–д Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах дунд хугацааны буюу 2017-2020 онуудад мэдээллийн технологийн кластер байгуулах замаар салбарын өсөлтийг дээшлүүлэх, шинэ зах зээл, бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болох боломж нөхцөлийг бүрдүүлэх; урт хугацааны буюу 2021-2025 онуудад өндөр технологи, инновацид суурилсан эдийн засгийн үр ашигтай, үйлдвэрлэлийн шинэ салбарыг төлөвшүүлэх, улс орны эдийн засаг, нийгэм, хүний хөгжилд оруулах үр нөлөөг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэхээр тусгасан.

Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 2020 – 2025: Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 95 дугаар тогтоолоор “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 2020 - 2025”⁷–д “Мэдээллийн технологи”-ийг хиймэл оюун хөгжүүлэх, хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологиор 1 дүгээрт эрэмбэлсэн. Тодруулбал, Төрөөс ложистик, тээвэр холбоо, хууль зүйн тусламж, үйлчилгээ, санхүүгийн ухаалаг үйлчилгээний чиглэлээр ажиллах хиймэл оюун ухааны

⁴ Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги (2002.11.20)
<https://www.legalinfo.mn/annex/details/1576?lawid=3193>

⁵ Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011.02.10)
<https://www.legalinfo.mn/annex/details/3362?lawid=6340>

⁶ Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/ (2017.02.08)
<https://www.legalinfo.mn/annex/details/7633?lawid=12496>

⁷ Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 2020 - 2025" (2020.03.18)
<https://www.legalinfo.mn/annex/details/10926?lawid=15247>

хөгжүүлэлтийн үндэсний компаниудыг бий болгох, тэдэнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, гадаадад ажиллаж байгаа өндөр ур чадвартай ажиллах хүчнийг тусгайлсан бодлогоор дэмжих замаар хиймэл оюуныг хөгжүүлэх, тэдгээрт суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэнэ; Засгийн газар үндэсний компаниудад захиалга өгөх, бүтээгдэхүүнийг худалдан авах дэмжлэгийг үзүүлснээр хиймэл оюун хөгжүүлэлтийн үндэсний компаниуд, бүтээгдэхүүн үйлчилгээ богино хугацаанд хөгжиж, эдийн засгийн үр ашгийг иргэд, олон нийт хүртэх боломжтой; үр дүнд хүрэх төсөөллийг тодорхойлсон байна.

Дээрх дурдсанчлан мэдээлэл технологийн салбарт төрөөс баримтлах бодлого, дэмжлэгийн хэлбэрүүдийг тусгасан ч Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд⁸ салбарын хуультай болгох, эсхүл холбогдох хуулийн шинэчилсэн найруулгыг батлах, мөн нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгаагүй байна. Тиймээс, бодлогын баримт бичгүүдэд тусгасан Мэдээллийн технологийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг урамшуулах эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлэх; Мэдээллийн технологийн хэрэглээг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн аюулгүй байдал болон мэдээллийн технологийн тухай хуулийн төсөл боловсруулах; Мэдээллийн технологийн хөгжлийг дэмжих зорилгоор холбогдох хууль эрхийн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах; зорилтын хүрээнд мэдээллийн технологийн салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг “Мэдээллийн технологийн салбарыг дэмжих тухай хууль”-д тусгаж, өргөн мэдүүлэх хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Үйл баримтын үндэслэл (Практик шаардлага)

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд “Мэдээллийн технологийн салбар”-ыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, эрх зүйн орчин бүрдүүлэх мөн тус салбарын бизнес эрхлэгчид дэмжлэг үзүүлэх ерөнхий зорилтууд тодорхойлсон. Харин судалгаанд оролцсон технологи хөгжүүлэлтийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй компаниуд мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг 73.2 хувь нь хүний нөөцийг чадавхижуулах; 63.3 хувь нь татварын орчин сайжруулах; 55 хувь нь дэд бүтцийг хөгжүүлэх, 54.1 хувь нь хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон.

Хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн бусад баримт бичигт мэдээллийн технологи, мэдээллийн технологийн компани, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний ангиллыг тодорхойлоогүйн улмаас Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрөөс дэмжихээр дурдсан “мэдээллийн технологийн компаниуд”, “мэдээллийн технологийн энтрепренер”, “хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компани” гэдгийг хэрхэн ойлгох, хэрэглэх хүрээ тодорхойгүй байна.

Мөн Монгол Улсыг урт болон дунд хугацаанд хөгжүүлэх бодлогын баримт бичигт дурдсан мэдээллийн технологийн салбарт холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн

⁸ <https://www.legalinfo.mn/annex/details/11551?lawid=16009>

стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар ханган ажиллах бүтэц, зохион байгуулалтыг тодорхой болгох шаардлагатай.

Дээрх үйл баримт нь мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд тодорхойлсон зорилтод нийцүүлэн шийдвэрлэх практик шаардлагыг бий болгосон.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн төслийн зорилго

Монгол Улсыг мэдээллийн технологийн гарааны бизнесийн эдийн засгийн чөлөөт бүс болгох хууль нь Монгол Улсыг мэдээллийн технологийн гарааны бизнесийн эдийн засгийн чөлөөт бүс болгож мэдээллийн технологийн салбар дахь хөрөнгө оруулалт, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэрүүдийг тодорхойлох, тус салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2.Хуулийн төслийн зохицуулах харилцаа

Мэдээллийн технологийн гарааны бизнесийн ерөнхий болон нэмэлт шаардлагыг хангасан мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчид төрөөс дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулна.

2.3. Мэдээллийн технологийн салбарыг дэмжих тухай хуулийн төсөл нь 6 бүлэг, 14 зүйлтэй байна.

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэг: Хуулийн зорилго, зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёог тусгана.

Хоёрдугаар бүлэг: Мэдээллийн технологийн гарааны бизнесийг эдийн засгийн чөлөөт бүст бүртгэх, түүнд тавигдах шаардлагыг тусгана.

Гуравдугаар бүлэг: Мэдээллийн технологийн гарааны бизнесийг дэмжих төрийн бодлогыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэг: Мэдээлэл технологийн салбарыг дэмжих талаар Засгийн газар, түүний тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын бүрэн эрхийг тусгана.

Тавдугаар бүлэг: Дэмжлэг авч буй хуулийн этгээдийн эрх, үүргийг тусгана.

Зургадугаар бүлэг: Бусад зүйл. Хууль хүчин төгөлдөр болох хугацаа, зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улсыг мэдээллийн технологийн гарааны бизнесийн эдийн засгийн чөлөөт бүс болгох хууль батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдэнэ:

1. Мэдээллийн технологийн гарааны бизнесийн нэр томъёог шинээр тодорхойлох замаар ойлголтын зөрөөтэй байдлыг арилгана.
2. Мэдээллийн технологийн гарааны бизнесийн салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлж хуульчилна.
3. Мэдээллийн технологийн салбарын оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжруулна.
4. Мэдээллийн технологийн салбарын Олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт татах боломж нээнэ.
5. Ажлын байр нэмэгдүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Монгол Улсыг мэдээллийн технологийн гарааны бизнесийн эдийн засгийн чөлөөт бүс болгох хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэж боловсруулагдана. Уг хуулийн төсөлтэй уялдуулан Компанийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

о О о